

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ  
ХАРИУЦСАН ГАЗРААС 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙЖ  
ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 06 дугаар сарын 17

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2010 оны “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, 2018 оны 145, 146 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 12 дугаар сарын 11-ээс 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 72 орны 420 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 18. Үүнд, нэг удаагийн орох 293, хоёр удаагийн орох 1, олон удаагийн орох 13, нэг удаагийн гарах-орох 65, хоёр удаагийн гарах-орох 4, олон удаагийн гарах-орох 24, дамжин өнгөрөх 2, түр ирэгчийн бүртгэл 135, хасалт 200, оршин суух зөвшөөрлийн хасалт 289 байна.

Дипломат төлөөлөгчийн газраас алдаатай олгосон 7 орны 15 гадаадын иргэний виз, ВЗХГ-аас алдаатай олгосон 3 орны 4 иргэний визийг хүчингүй болгосон. Мөн Монгол Улсад 180 хоногоос дээш хугацаагаар зорчсон, хөрөнгийн эх үүсвэргүй 8 орны 27 гадаадын иргэний визийг хүчингүй болгож буцаасан байна.

1.2. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Тус газраас явуулах хяналт шалгалтын 2020 оны төлөвлөгөөг боловсруулж энэ оны 1 дүгээр сарын 2-ны өдөр Хяналт шалгалтын газарт хүргүүлэн байгууллагын даргаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт 5, төлөвлөгөөт бус 1, нийт 6 хяналт шалгалтыг зохион байгуулсан. Төлөвлөгөөт хяналт шалгалтад давхардсан тоогоор нийт 22 аж ахуйн нэгж, байгууллага, 7 орны 43 гадаадын иргэн хамрагдсан ба зөрчил илрээгүй. Харин төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 1 аж ахуйн нэгжийн урилгаар ирсэн 1 орны 9 гадаадын иргэн визийн хугацаа хэтрүүлсэнийг илрүүлж Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. Хяналт шалгалтын дүнг тухай бүр тус газрын дарга болон Хяналт шалгалтын газарт илтгэх хуудсаар танилцуулсан.

Үүнээс гадна дотоод сүлжээгээр давхардсан тоогоор 49 орны 27,768 гадаадын иргэний мэдээллийг шүүж шалгасан ба 1 орны 1 гадаадын иргэнийг гарах-орох визгүй улсын хилээр гаргасан зөрчлийг илрүүлж хилийн 0218 дугаар ангийн захирагчид 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 10/17 дугаарын албан бичгээр, хасалтын хугацаа хэтэрсэн 1 орны 1 гадаадын иргэнийг улсын хилээр гаргасан зөрчлийг тус тус илрүүлж холбогдох арга хэмжээ авч хариу мэдэгдэх хүсэлт явуулсан. Мөн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн УБ-Сөүл чиглэлийн ОМ-301

тусгай үүргийн нислэгээр зорчиж байсан 1 орны 1 гадаадын иргэн 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдөр ирж түр ирэгчийн бүртгэл хийлгээгүй гарсан байсныг илрүүлж онгоцноос буулган ЗТХ-ийн 16.2.1.1.1-т заасны дагуу торгуулийн арга хэмжээ авч түр ирэгийн бүртгэл, хасалт хийж явуулсан.

Орон нутгийн нислэгээр зорчиж байсан болон угтан авч үдэн гаргагч гадаадын иргэний хөдөлгөөнд 12 удаагийн шалгалтаар 6 орны 17 гадаадын иргэний паспорт бичиг баримтад шалгалт хийсэн.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага /IOM/-аас өгсөн бичиг баримтын хуурмаглал шалгах төхөөрөмжийг ашиглан тайлант хугацаанд нийт 8 орны 31 гадаадын иргэний бичиг баримт, мэдээллийг шалгасан. Дээрх байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус төхөөрөмжийг ашиглаж шалгасан гадаадын иргэдийн талаарх мэдээг нэгтгэн гаргаж 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр харин 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөн оны 2 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар тус төхөөрөмжийг ашиглаж шалгасан талаарх мэдээг нэгтгэн гаргаж 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдөр цахим хаягаар тухайн байгууллагад хүргүүлсэн болно.

#### 1.3. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Тайлангийн хугацаанд бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 12 орны 53 гадаадын иргэнд 9,650,000 төгрөг, 21 аж ахуйн нэгжид /хамрагдсан 39 гадаадын иргэн/ 15,710,000 төгрөг, нийт 25,360,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.

#### 1.4. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд визийн хугацаа хэтрүүлсэн, виз, бүртгэлийн журмыг 1 жилд 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн 4 орны 5 гадаадын иргэнийг тус улсаас албадан гаргасан болно. Харин төвд 12 орны 23 гадаадын иргэнийг албадан гаргасан талаар тодорхойлолт үйлдэн хүргүүлэв.

#### 1.5. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсаас албадан гаргагдаж орохыг хориглосон хугацаа нь дуусаагүй байсан 1 орны 2 гадаадын иргэн, орох виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 2 орны 2 гадаадын иргэн, Улсын онцгой комиссоос тогтоосон улсад зорчсон 6 орны 6 иргэнийг тус тус улсын хилээр оруулаагүй буцаасан байна.

Мөн гарах-орох визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр 12 орны 28 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно.

Шүүх, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

#### 1.6. Ярилцлагын тэмдэглэл болон баталгаа гаргуулан хил нэвтрүүлсэн талаар:

Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 14 орны 79 гадаадын иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно.

Монгол Улсад зорчин ирж буй 5 орны 21 гадаадын иргэнийг угтан авч буй уригч 6 иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

#### 1.7. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 6 орны 10 иргэнээр өргөдөл-анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч Виз, зөвшөөрөл, харьяатын газарт хүргүүлсэн.

#### Хоёр. Дотоод ажлын хүрээнд

##### 2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын дарга нийт 17 /үндсэн үйл ажиллагаатай холбоотой 7, хүний нөөцтэй холбоотой 10/ тушаал батлан гаргаж биелэлтийг тооцсон.

Төсвийн шууд захирагч АЗБХГ-ын дарга 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төсвийн төвлөрүүлэн захирагч ГИХГ-ын даргатай 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр байгуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн албан хаагчид 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө тус газрын даргатай 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр байгуулав. Нэгжийн 2020 оны 1 дүгээр улирлын тайланг энэ оны 4 дүгээр сарын 10-ны өдөр төвд хүргүүлсэн бөгөөд албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг авч дүгнэсэн.

Тус газрын 2020 оны 1-6 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр баталж хэрэгжүүлж ажилласан бөгөөд биелэлтийг мөн сар бүр тооцсон. Мөн архив, албан хэрэг хөтлөлт, сургалтын талаар 2020 онд хийх ажлын төлөвлөгөө, Төв аймгийн Цагдаагийн газартай 2020 онд хамтан ажиллах төлөвлөгөө, 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төвөөс өгсөн үүргийн дагуу дараах мэдээг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүлээ. Үүнд:

- Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст:

- тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр;
- байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг сар бүр;
- боомтод 2020 оны 1 дүгээр улиралд ажиллах албан хаагчдын хувиарийг гаргаж батлуулсан ба өргөдөл, гомдлын мэдээ, инфографик мэдээг гаргаж сар бүр;
- байгууллагын даргын шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, “Орон нутаг дахь газар ажиллах журам”-д оруулсан нэмэлтийн талаар тус газрын албан хаагчдад танилцуулж гарын үсэг зурсан баталгааг 4 дүгээр сард.

- Захиргаа, удирдлагын газарт:

- байгууллагын хөгжилд хувь нэмрээ оруулсан албан хаагчдыг шагнуулахаар холбогдох материалыг бэлтгэн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний 2019 оны жилийн эцсийн биелэлтийг гаргаж 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр;
- тус газраас хууль эрх зүйн талаар мэдээллийн самбар бэлтгэж Буянт-Ухаа боомтод байршуулсан талаарх мэдээг 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр;
- Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн цахим програмд оруулсан тус газрын албан хаагчдын талаарх 1-6 дугаар сарын мэдээ;

-албан хаагчдаар төрийн албан хаагчийн анкетийг шинэчлэн, амжиргааны түвшин тогтоох судалгааг ирүүлсэн загварын даргуу гаргаж 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр;

-тус газарт 2020 оны 1-6 дугаар сард ирсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээг 2019 оны мөн үетэй харьцуулан гаргаж сар бүр;

-хяналтын улсын байцаагчийн сургалтанд хамрагдах албан хаагчдын талаарх судалгаа болон Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын цалингийн сүлжээний талаарх судалгааг тус тус гаргаж 1 дүгээр сарын 8-ны өдөр;

-байгууллагын 2020 оны сургалтын төлөвлөгөөнд тусгах саналаа 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөнд тусгах саналаа мөн сарын 23-ны өдөр, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд тусгах саналаа мөн сарын 27-ны өдөр;

-албан хаагчдын 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн тайланг үнэлж урамшуулал олгох саналыг 2020 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр;

-боомтод ажилласан урамшууллын мөнгө 2021 онд авах албан хаагчдын талаарх судалгааг 4 дүгээр сарын 9-ний өдөр, албан хаагчдын төрийн албанд ажилласан жилийн судалгааг гаргаж мөн сарын 13-ны өдөр, “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн эрх олгох, уг эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох” журамд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан тус газраас тусгах санал болон тус газрын даргын 2020 оны нэгдүгээр улиралд батлан гаргасан тушаалыг 17-ны өдөр, өрх толгойлсон ганц бие эцэг, эхийн талаарх судалгааг ирүүлсэн загварын дагуу гаргаж 23-ны өдөр;

-хугацаат цэргийн алба хаасан болон цэргийн сургуульд сонсогчоор суралцсан албан хаагчийн талаарх судалгааг гаргаж 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдөр.

## 2.2. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар:

Тайлант хугацаанд 2019 онд үүссэн архивын нэгжийг хүлээн авах хувиарийг энэ оны 1 дүгээр сарын 15-ны өдөр батлан гаргасан. Хувиарийн дагуу албан хаагчдаас архивын нэгж хүлээн авсан. Архивын өрөөний чийг, дулааныг ажлын өдөр бүр хэмжиж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Бичиг хэрэгт 105 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 53 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 57 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй болно.

Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан тушаал, тус газрын сар бүрийн төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн болно.

## 2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

Байгууллагын даргын 2018 оны Б/347 дугаар тушаалын дагуу тус газрын батлагдсан орон тоо 29 бөгөөд одоо ажиллаж байгаа 24 албан хаагчаас өвчтэй 1 байна. Батлагдсан хувиарийн дагуу ээлжийн амралт эдэлсэн 11, декреттэй 2, хүүхэд асрах чөлөөтэй 2 байна.

2019 онд ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа хошуучлан ажилласан тус газрын 1 албан хаагчийг ГИХГ-ын “Хүндэт тэмдэг”, 1 албан хаагчийг ГИХГ-ын даргын тушаалаар мөнгөн шагналаар, АЗБХГ-ын даргын тушаалаар 2 албан хаагчийг мөнгөн шагналаар тус тус шагнасан. Ёс зүйн хариуцлагын талоныг шинэчилсэнтэй холбогдуулан 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр нийт 28 ширхэгийг хүлээн авч албан хаагчдад хүлээлгэн өгсөн болно. Тайлант хугацаанд Ёс зүйн хариуцлагын талонд арга хэмжээ авахуулсан албан хаагч байхгүй болно.

Тус газрын албан хаагчдын 2019 оны гүйцэтгэлийн тайланг дүгнэж 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр төвд хүргүүлсэн бөгөөд 22-ны өдөр үнэлгээний багаар үнэлүүлсэн. Харин 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн тайланг дүгнэж хангалттай үнэлэгдсэн 18 албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон. Төрийн албаны зөвлөлийн програмд албан хаагчдын 2019 оны гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ, 2020 онд шинэчилсэн цалингийн сүлжээ, нэмэгдэл, шагнал, тус газарт томилогдсон, шилжин явсан, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид зэрэг мэдээллийг тухай бүр шивж оруулав.

Тус газрын 2019 оны сургалтын төлөвлөгөө, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний биелэлтийг гаргаж төвд 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлсэн ба архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 2019 онд хийх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргав.

Тайлант хугацаанд төв болон тус газраас зохион байгуулсан сургалтуудад албан хаагчдыг хамруулж ажиллалаа.

Төвөөс зохион байгуулсан дараах сургалт, цугларалтанд албан хаагчдыг хамруулав:

- 2020 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх сургалтад тус газрын 13 албан хаагч, 1 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд байгууллагын даргын 2020 оны А/14 дүгээр тушаалын дагуу удирдах албан тушаалтан, албан хаагчдын цугларалт, сургалтанд тус газрын 7 албан хаагч хамрагдлаа;

- 2020 оны 4 дүгээр сард зохион байгуулсан хяналтын улсын байцаагчийн эрх олгох сургалтанд тус газрын 1 албан хаагч хамрагдаж, сүлжээний инженерээр томилогдсон 1 албан хаагч төвд дадлагажуулах сургалтанд хамрагдав;

- 2020 оны 05 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны сургалтанд тус газрын 1 албан хаагч хамрагдаж АЗ сертификатын шалгалтанд тэнцсэн ба мөн сарын 27-ны өдөр “Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн тус байгууллагатай хамааралтай заалтын талаар зохион байгуулсан цахим сургалтанд тус газрын 10 албан хаагч хамрагдав.

Тус газраас зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчдыг хамруулав:

- 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр виз, зөвшөөрөл, хяналт шалгалтын чиглэлээрх сургалтыг цахимаар явуулсан бөгөөд нийт 15 албан хаагч хамрагдсан;

- 2020 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотын шинэ нисэх буудалтай танилцах сургалтанд нийт 19 албан хаагчийг хамруулав.

#### 2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсөв болох 339,745,400 төгрөгийн санхүүжилт орсноос цалин хөлсөнд 180,079,761 төгрөг, ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 26,238,000 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 7,229,849 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган сар бүрийн 5-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 42,055,146 төгрөгөөр тооцоо нийлэв. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 2-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 283,436,700 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 235,960,680 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.

Албан хаагчдад шийтгэлийн хуудас, визийн хуудас олгосон бөгөөд Баруун бүс дэх газарт 191 ширхэг визийн хуудас 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр шилжүүлсэн. Хүү торгууль 25,360,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж 38,114,790 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 1,211,472 төгрөг, байрны түрээс 17,964,500 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс уруу шилжүүлсэн болно.

Бараа материалд 5,132,100 төгрөгийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна. Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Түлш шатах тослох материалд 10,407,000 төгрөг ажил үйлчилгээ хийв.

Тус газрын албан хаагчдын нийгмийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

Үйлчилгээнд явж буй Приус-20, Соната-7 автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав. Мөн тээврийн хэрэгслүүдэд 741,900 төгрөгөөр авто тээврийн оношилгоо, татвар, даатгалын үйлчилгээг хийлгэсэн.

## 2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд сүлжээ болон техник хэрэгслийн өдөр тутмын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан. Дотоод сүлжээ энэ хугацаанд хэвийн ажилласан ба шинэчлэлийг хийсэн. Тус газрын компьютерүүдийн хэвийн ажиллагааг шалгасан ба “Linphone” програмыг ашиглахтай холбоотой тус газрын нийт компьютер болон дагалдах хэрэгслийг тоолж шаардлагатай төхөөрөмжийг тодорхойлж худалдан авалт хийж суурьлуулсан. Тус газрын албаны компьютерийг хортой кодноос хамгаалах зорилгоор холбогдох судалгааг хийж 637,000 төгрөгийн антивирусын программыг “Киберком” ХХК-аас 2020 оны 6 дугаар сард худалдан авч албаны компьютерүүдэд суулгахаар ажиллаж байна.

Тус газрын сүлжээний инженер төвд ажиллах хугацаандаа албан хаагчдын компьютерийн тоног төхөөрөмжийн үзүүлэлт болон программын бүртгэлийг хийсэн

бөгөөд 3 давхарт камер тавих ажлыг Мэдээллийн технологийн хэлтсийн инженертэй хамтарч хийв. Мөн 100 ширхэг статистикийн эмхэтгэл номын хэвэлсэн ба “BGP in Large Network” сүлжээний технологийн талаарх судалгааны ажил хийсэн. Үүнээс гадна байгууллагын цахим хуудаст байршуулсан цахим визийн зөвшөөрөл олгох хэсгийн хөгжүүлэлтийн ажлыг хийхэд оролцож хэрэглэгчийн шаардлага хийж бүртгэл хөтөлсөн.

#### Гурав. Олон нийттэй харилцах чиглэлээр

Тус газрын мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсанд сар бүр хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлт, тайлан, зохион байгуулсан сургалт, өргөдөл, гомдлын мэдээ, жилийн эцсийн тайланг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж сурталчилах, танин мэдүүлэх зорилгоор биечлэн 387, утсаар 425 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

#### Дөрөв. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний талаар

“Чингис хаан”, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлуудад байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах орон тооны талаарх судалгааг гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст тухай бүр хүргүүлсэн.

Хөшигийн хөндийд баригдсан Улаанбаатар хотын шинэ олон улсын нисэх буудалд 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдөр тус газрын 4, Мэдээллийн технологийн хэлтсийн 5 албан хаагчид сүлжээний сувагчлал, өрөөний зохион байгуулалттай, 2020 оны 5 дугаар сарын 8-ны өдөр тус газрын 19 албан хаагчид байгууламжтай танилцав.

Шинэ нисэх буудалд байрлах өрөөний “Оффисын түрээсийн гэрээ”-г төслийн хэмжээнд “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-аас хүлээн авч Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн хуулийн ахлах мэргэжилтнээр 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр хянуулсан бөгөөд гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан.

Шинэ нисэн буудалд 2020 оны 5 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулсан хуралд тус газрын 2 албан хаагч оролцож Орат тестинг төлөвлөгөөний талаарх танилцуулга, төлөвлөгөөг хэлэлцэж санал солилцсон агаарын навигацын үйлчилгээний газрын нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц болон шалгалтын нислэгийн талаар хэлэлцсэн.

Шинэ нисэх буудал уруу нүүхтэй холбоотой тавилга эд хогшилын судалгааг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан шинэ нисэх буудалд байрлах өрөөнд тавилга, эд хогшил нийлүүлэх тендерт шалгарсан “БИОМЕДИКАЛ ИНЖЕНЕРИНГ” ХХК-тай 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр тавилга, эд хогшил худалдан авах гэрээг байгуулсан.

Үүнээс гадна нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардлын задаргааг 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдөр [tsengel.b@mcaa.gov.mn](mailto:tsengel.b@mcaa.gov.mn) цахим хаягаар ажлын хэсэгт хүргүүлсэн ба мөн өдөр нүүргэн шилжүүлэх хорооны ажлын хэсгийн 7 дугаар хуралд ЭЗГХХ-ийн хуулийн ахлах мэргэжилтэн, тус газрын хяналтын улсын ахлах байцаагч нар хамрагдсан бөгөөд зорчигчийн урьдчилсан мэдээллийн системийн талаар мэдээлэл хийсэн.

Визийн хураамжаас чөлөөлсөн хэлэлцээрийг нэгтгэж гарын авлага гаргах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, гадаад улсын Засгийн газар болон олон улсын байгууллагатай хийсэн нийт 12 хэлэлцээрийг нэгтгэж ЭЗГХХ-ээр хянуулахаар 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлсэн.

#### Тав. Бусад

Ээлжийн ахлахууд “Чингис хаан” ОУНБ-ын ерөнхий зохицуулагчийн 10:00 цагийн шуурхай хуралд тогтмол сууж хил хяналтын бусад байгууллагуудтай мэдээлэл солилцон хамран ажилласан байна.

Тус газрын 2019 оны тайлангийн хурлыг 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, жилийн ажлаа тайлагнасан. Мөн нийт албан хаагчдын хурлыг 2 удаа зохион байгуулж албаны үйл ажиллагааны талаар хэлэлцэж байгууллагын удирдлага, газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээс үүрэг чиглэл авч мөрдөн ажиллаж байна. Мөн төв газраас зохион байгуулсан цахим сургалтанд тухай бүр хамрагдсан болно.

Төв газраас зохион байгуулсан спортын арга хэмжээнд тус газрын албан хаагчид хамрагдаж авхаалж самбаагаа сорив.

Коронавирусын дэгдэлт дэлхий дахинд гарсантай холбогдуулан тус газрын албан хаагчдыг халдвар авахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нэг удаагийн маск, хувцас, гар ариутгагч, денутратны спирт, дархлаа дэмжих салимон, аньс, чацарганы шүүс, хувцас ариутгагч дермобактерийн шингэнээр тухай бүр ханган ажиллаж байна.

Агаарын тээврийг хялбаршуулах хорооны цахим хуралд тус газрын 2 албан хаагч 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр оролцож авиа компаниудын нислэгийн хувиар, ковид-19 урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийсэн.

Төв газраас зохион байгуулсан цахим хуралд тус газрын албан хаагчид хамрагдаж байгууллагын удирдлагаас үүрэг, чиглэл авч ажиллаж байна.

Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит 2020 оны 4 дүгээр сард орсонтой холбогдуулан шаардсан бүх баримтыг гарган өгч, холбогдох мэдээллээр ханган ажилласан. Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга, дотоод аудит нарын оролцсон тус газрын санхүүгийн үйл ажиллагаанад хийсэн шалгалтын дүнг танилцуулах хурлыг 2020 оны 5 дугаар сарын 4-ний өдөр хийж баталгаажуулсан бөгөөд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.